



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 1 сарын 16 өдөр

Дугаар 18.

Улаанбаатар хот

“Ногоон буудал” эко шошго хэрэглэх
эрх олгох журмыг шинэчлэх тухай

ТУШААХ НЬ:

Нэг. МҮХАҮТ-аас олгох “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх олгох журмыг Хавсралтанд заасны дагуу шинэчлэн баталсугай.

Хоёр. “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх олгох журмыг тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэн, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ЦХЦҮДГ-ын дарга /Г. Түмэнжаргал/-д даалгасугай.

ДАРГА



С. ДЭМБЭРЭЛ



МҮХАҮТ-ын даргын 2012 оны 16 сарын 16 өдрийн
№ 16 тоот тушаалын хавсралт № ...

**“НОГООН БУУДАЛ”
ЭКО ШОШГО ХЭРЭГЛЭХ ЭРХ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1 “Ногоон буудал” эко шошго нь байгаль орчинд ээлтэй үйлчилгээний менежмент нэвтрүүлж буйг гэрчлэх тэмдэг бөгөөд зочид буудал, зочлох үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хамаарна.
- 1.2 “Ногоон буудал” эко шошго нь тухайн байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу, сайн дурын үндсэн дээр олгогдоно.
- 1.3. “Ногоон буудал” эко шошгоны лого, тодорхойлолтыг энэ журмын Хавсралт 1-ээр батлав.

Хоёр. “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх олгох

- 2.1 “Ногоон буудал” эко шошго олгох үндсэн шалгуур нь холбогдох байгаль орчны хууль, тогтоомжийн бүх заалтуудыг биелүүлсэн байх явдал юм.
- 2.2 “Ногоон буудал” эко шошго олгох шалгууруудыг энэ журмын Хавсралт 2-оор баталсан ба зочид буудал, зочлох үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд өөрийн хувьд хамгийн бололцоотой 5 шалгуурыг хангаснаар нэг, 8 шалгуур хангаснаар хоёр, 10 шалгуур хангаснаар бол гурав, 12 шалгуур хангаснаар бол дөрөв, 14 шалгуур хангаснаар таван “Ногоон буудал” эко шошго тус тус хэрэглэх эрхтэй болно.
- 2.3 “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх авахыг хүссэн аж ахуйн нэгж нь дараах материалыг бүрдүүлж МҮХАҮТ-д ирүүлнэ. Үүнд:
 - 1. Шошго хэрэглэхийг хүссэн өргөдөл/албан бичиг (бүтээгдэхүүн, үйлчилгээнд шошгыг ямар учраас хэрэглэх болсон талаарх тайлбар),
 - 2. Байгууллагын гэрчилгээний хуулбар, тусгай зөвшөөрөл
 - 3. Байгууллагын үйл ажиллагааны танилцуулга (байршил, үйлчилгээний хэлбэр, хугацаа г.м.)
 - 4. Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн заалтуудад нийцэж байгааг баталгаажуулсан байна.
 - 5. Хавсралт 2-т заасан шалгууруудаас алийг хангаж байгаа талаар тодорхойлолт
- 2.4 Өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор МҮХАҮТ-ийн Цэвэр хөгжил, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих газрын болон “Ногоон зочид буудлын зөвлөл”-ийн мэргэжилтнүүд хамтран газар дээр нь үнэлгээ хийнэ. Шаардлагатай гэж үзвэл холбогдох баримтуудыг дахин үнэлүүлэхээр холбогдох газруудад шилжүүлж, дахин магадлуулахаар өргөдөл гаргагчид буцааж болно.

2.5 МҮХАҮТ-ын дэргэдэх “Ногоон зочид буудлын зөвлөл”-ийн хурлаас холбогдох шалгууруудыг хангасан байдлыг үндэслэн “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрхийг баталгаажуулна.

2.6 “Ногоон зочид буудлын зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн МҮХАҮТ-ын ЦХЦҮДГ-аас Хавсралт 3-ын дагуу гэрчилгээ олгож, гэрээ байгуулна.

Гурав. “Ногоон буудал” эко шошго хэрэглэх гэрээний үндсэн нөхцөл

3.1 Гэрээ нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг тодорхойлох ба “Ногоон буудал” эко шошгыг зар сурталчилгаанд ашиглах, хэрэглэгчдийг төөрөгдүүлэхээс зайлсхийх, ашиглалттай холбогдолтой зарим нөхцөлүүдийг тодорхойлсон байна.

3.2 “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрхийг 3 жилийн хугацаагаар олгох ба гэрээ байгуулснаас хойш тухайн оны дараах улирлын эхний сарын нэгнээс эхлэн эко шошго албан ёсоор хүчин төгөлдөр болж хэрэглэгдэж эхлэнэ.

3.3 “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх авсан байгууллага цаашид үйл ажиллагаагаа байгаль орчинд илүү ээлтэй болгох замаар “Ногоон буудал” зэрэглэлээ нэмэх, үйл ажиллагааг тогтворжуулах, боловсронгуй болгох төлөвлөгөө гаргаж ажиллана.

3.4 “Ногоон буудал” эко шошгыг үр ашигтай хэрэглэх боломжуудын жишээ:

- ✓ Үйлчилгээний танилцуулга, каталог, интернет хаягууд дээр байршуулах
- ✓ Аж ахуйн нэгж, байгууллагын болон сурталчилгааны танилцуулга дээр /албан бичиг, плакат, сонин хэвлэлийн нийтлэлд/
- ✓ Байгууллага, худалдааны төвийн үүдэнд байршуулах, сурталчлах /наах, хавчих, танилцууллага хэлбэрээр/
- ✓ Үзэсгэлэн, яармагт ашиглах

Дөрөв. “Ногоон буудал” эко шошгыг хэрэглэх хугацааг сунгах

4.1 Хэрвээ үйлчилгээ нь холбогдох шалгууруудыг хангасан, гэрээний шаардлагад нийцсэн хэвээр байвал “Ногоон буудал” эко шошгыг хэрэглэх хугацааг дахин 3 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

4.2 Тухайн аж ахуйн нэгж нь “Ногоон буудал” эко шошгыг хэрэглэх гэрээний хугацаа дуусахаас хамгийн багадаа 2 сарын өмнө гэрээг дахин сунгах хүсэлтээ өргөдлөөр гаргах ёстой.

Тав. “Ногоон буудал” эко шошгыг хэрэглэх эрх цуцлагдах

МҮХАҮТ-ын “Ногоон зочид буудлын зөвлөл”-ийн хурлаас тухайн байгууллагад хийсэн шалгалт, дүгнэлтийг үндэслэн шошго хэрэглэх эрхийг цуцалж, бүртгэлээс хассан тохиолдолд “Ногоон буудал” эко шошго ашиглах эрх цуцлагдана.

Зургаа. Хураамж

6.1 “Ногоон буудал” эко шошго авч байгаа байгууллагууд элсэлтийн болон жилийн хураамж төлөх ба энэ нь веб сайтыг ажиллуулах, зар сурталчилгаа хийх, хяналт шалгалт хийх, зөвлөгөө өгөх, үзэсгэлэн яармаг зохион байгуулах зэрэг 7-р зүйлд заасан тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлуудад зарцуулагдана.

6.2 Хураамжийн хэмжээ

Ангилал	Элсэлтийн хураамж, Төгрөг	Жилийн хураамж, Төгрөг
1	50000	50000
2	100000	100000
3	150000	150000
4	200000	200000
5	300000	300000

Ангилал 1: 20 хүртэл ортой аялал жуулчлалын газар

Ангилал 2: 21-50 хүртэл ортой жуулчлалын газар. Хоолны газартай, бүлэг жуулчдыг авах чадамжтай, өөрийн талбай, газартай болон байртай

Ангилал 3: 50-100 хүртэл ортой. /бусад үзүүлэлтүүд Ангилал 2-той адил/

Ангилал 4: 101- 200 хүртэл ортой. /бусад үзүүлэлтүүд Ангилал 2-той адил/

Ангилал 5: 200 ороос дээш. /бусад үзүүлэлтүүд Ангилал 2-той адил/

6.3 Жилийн хураамжийг тухайн жилийн 1-р сард төлнө.

Долоо. Тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэх

7.1 Тухайн шошгоны холбоотой үйл ажиллагаа, төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг жилд нэг удаа МҮХАҮТ-ын “Ногоон зочид буудлын зөвлөл” ба Цэвэр хөгжил, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих газраас шалгаж зөвлөгөө өгнө.

7.2 МҮХАҮТ-ын “Ногоон зочид буудлын зөвлөл”, Цэвэр хөгжил, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих газар, Зочид буудлуудын холбоо хамтран жил бүр “Ногоон буудал” үзэсгэлэн яармаг зохион байгуулж, “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх авсан байгууллагуудын үйл ажиллагааг сурталчилна.

7.3 МҮХАҮТ-ын “Ногоон зочид буудлын зөвлөл” - өөс www.greenhotel.mn вэб сайт ажиллуулж “Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх авсан байгууллагуудын үйл ажиллагааг сурталчилах, ногоон буудлуудын сүлжээг байгуулах, аргачлал, туршлагыг дэлгэрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

“Ногоон буудал” эко шошго хэрэглэх
эрх олгох журам”. Хавсралт 1



“Ногоон буудал” эко шошгоны тодорхойлолт



Шошгоны тодорхойлолт:

1. Уг эко шошго нь Монгол гэрийн хэлбэртэй.
2. “Ногоон буудал” утгыг хадгалсан.
3. “Green hotel” бичиглэлээр болон гэрийн янданг навчаар дүрсэлж байгаль орчинд ээлтэй утгыг илэрхийлсэн



“Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх олгох журам” Хавсралт 2

“Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх авахын тулд хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнүүд ба шалгуурууд

Хэрэгжүүлвэл зохих арга хэмжээ	Зорилго/гарах үр ашиг	Шалгуур
Нүүр гарын алчуур, орны цагаан хэрэглэлийг хамгийн цөөн солих менежмент хэрэгжүүлэх (зөвхөн зочдын саналын үндсэн дээр).	Угаалганд зарцуулах эрчим хүч, усны хэрэглээ багасна.	- Ор, ариун цэврийн өрөөнд “Бид байгаль орчноо хамгаалж, усыг ариг гамтай хэрэглэдэг. Та ...-г солих шаардлагатай гэж үзвэл энэ хуудсыг ...-д тавина уу...” гэсэн хуудсыг зочдын өрөө бүрд байрлуусан байна.
Сэргээгдэх эрчим хүч ашиглах	Нар, салхи, ус, биомасс ашиглан эрчим хүч гарган авах нь цэвэр эрчим хүчний эх үүсвэрүүд болно.	Эрчим хүчний хангамжийн 51-ээс дээш хувь нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хангагдаж байна.
Эрчим хүчний менежмент нэвтрүүлэх	Халаалт, хөргөлт, агааржуулалт, гэрэлтүүлгийн зардлыг бууруулах ба ус хэмнэж, гарах бохирдол буурна.	- Зочдын өрөө, гудам, танхимуудад гэрлээ унтраах сануулга хадсан, - Сүүлийн үеийн эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмж ашигладаг, - ашиглаагүй төхөөрөмж, гэрэлтүүлгийг унтрааж байх талаар зааварчилга гаргасан, -
Өдрийн гэрэл ашиглах	Улайсах гэрэл ашигласнаас 2 дахин бага эрчим хүч ашиглана.	100%
Ус хэмнэлттэй шүршүүр/жорлон, автомат мэдрэгчтэй угаалтуур ашиглах	Татуургын болон угаалгын усны хэрэглээ багасах ба шүршүүрийн халуун усны зарцуулалт буурснаар эрчим хүч, усны хэрэглээ мөн буурна.	Нийт шүршүүр, жорлон, угаалтуурын 51-ээс дээш хувь нь ус хэмнэлттэй, автомат мэдрэгчтэй байх
задгай (жижиглэн боогоогүй) саван, ариун цэврийн хэрэгсэл ашиглах	Хаягдлын хэмжээ эрс багасна.	100%
Эргүүлэн ашиглах: сонин, цаас, шил, лааз, картон цаас, хуванцар сав зэргийг эргүүлэн ашиглах	Хаягдлыг ялгаж дахин боловсруулснаар хогийн цэгт хаях хаягдал буурна.	Хогийг бүрэн цуглуулах, ангилах, дотооддоо буюу өөр компаниудаар дамжуулж эргүүлэн ашиглах, дахин боловсруулах тогтолцоог бий болгосон.
Хүнсний хаягдлыг ашиглах	Хүнсний хаягдлаас метан (хүлэмжийн хий) ялгарахаас сэргийлэх ба бордоо, амьтны тэжээл хийх зэргээр ашиглах боломжтой.	Хүнсний хаягдлыг дотооддоо буюу өөр компаниудаар дамжуулж бүрэн ашиглах тогтолцоог бий болгосон.
Хоолны цэсэндээ органик хүнс санал болгох	Пестицид, гормон, химийн бордоо, азот, гербицид зэрэг хорт	-Зочдод санал болгож буй хоолны цэсэнд органик хүнс 20-иос доошгүй






	бодисоор хөрс, ус бохирдохоос сэргийлнэ.	хувь эзэлж байх. - Органик газар тариалан, мал аж ахуй эрхлэгчид, дэлгүүртэй хангамжийн гэрээ байгуулсан. - Органик хүнсний бүтээгдэхүүнийг тусад нь хадгалдаг
Хоргүй, байгаль орчинд ээлтэй цэвэрлэгээний бодисууд ашиглах	Хаягдал усаар дамжин агаар, ус, хөрс химийн хортой бодисоор бохирдохоос сэргийлнэ.	- цэвэрлэгээний бодис ашиглалтын бүртгэл хөтөлдөг. - Хаягдал бохир усыг цэвэрлэх төхөөрөмжтэй.
Үйлчилгээнд шилэн/шаазан/мөнгөн аяга, таваг зэрэг олон дахин ашиглах хэрэглэгдэхүүнүүд ашиглах	Нэг удаагийн хэрэглээний аяга савны хог хаягдлыг багасгана.	100%
Цэвэр агаар солилцооны систем	Цонхыг нээх боломжтой байх нь зочдод цэвэр, эрүүл агаараар амьсгалах боломж олгоно.	Зочдын өрөөний цонхууд 100% нээх боломжтой байх.
уудлын танилцуулга, хоолны цэс, тэмдэглэлийн цаас зэрэгт дахин боловсруулсан буюу хлоргүй боловсруулсан цаас ашиглах	Шаардлагагүй хэвлэхгүй байх, хоёрдогч цаас ашиглах зэргээр цаасыг үр ашигтай ашиглах, ашигласан цаасыг цуглуулж дахин боловсруулалтад өгөх нь цаасны хэрэглээний байгаль орчны нөлөөлийг 75–95% бууруулна. 100 боодол хоёрдогч цаас хэрэглэснээр 2 мод огтлох, 1 тонн илүү хүлэмжийн хий ялгарахаас сэргийлнэ	Нийт хэрэглээний цаасны 51-ээс дээш хувь нь дахин боловсруулсан буюу хлоргүй боловсруулсан цаас байна.
Ажиллагсад, зочдод ногоон боловсролыг санал болгох	“Ногоон буудал”, “Ногоон аялал жуулчлал”-ын зарчмуудыг сурталчилснаар үр хүүхэддээ ногоон ирээдүйг хадгалж үлдэнэ.	- Ажиллагсад “Ногоон буудал” эко шошгоны зорилго, ач холбогдлыг гүн гүнзгий ойлгосон, - Ажиллагсад “Ногоон буудал”, “Ногоон аялал жуулчлал”-ын зарчмууд, аргачлалын талаар сургалт явуулдаг - Зочдын өрөөнд “Ногоон навч”, - “Ногоон аялал жуулчлал”, “Ногоон буудал”-ын талаар хэвлэмэл материал байрлуулсан



“Ногоон буудал” эко шошго хэрэглэх эрх олгох журам”. Хавсралт 3

“Ногоон буудал” эко шошгоны гэрчилгээ


“Ногоон Буудал” Тэрчилгээ

“Улаанбаатар Зочид буудал”-д

1. Сэргээгдэх эрчим хүч ашигласан
2. Эрчим хүчний менежментийг ашигласан /халаалт, хөргөлт агваржуулалтын зардлыг бууруулсан/
3. Усны хэрэглээг багасгах менежмент хэрэгжүүлсэн
4. Өдрийн гэрэл ашигласан
5. Ус хэмнэлттэй шүршүүр жорлон, автомат мэдрэгчтэй угаалтуур ашигласан
6. Задгай саван болон арнун цэврийн хэрэглэл ашигласан
7. Хаагдлыг ялгаж хаян, дахин боловсруулсан
8. Хүнсний хаягдал ашигласан

8 шалгуур хангасан тул хоёр “Ногоон Буудал” эко шошго хэрэглэх эрхийг 3 жилийн хугацаатай олгов.



МУХАУТ-ын дэргэдэх “Ногоон Буудал” Зөвлөл
Цэвэр Хөгжил, Цэвэр Үйлдвэрлэлийг Дэмжих Газар

2012 оны 1-р сарын 13 өдөр